

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Намжил

Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.ШИНЭБАЯР
ТАНАА

2023.02.15 № УВА-2023/52/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Улсын бүртгэлийн Ерөнхий газар төлөвлөгөө гарган хэрэгжилтэд дотоод аудитын дүгнэлт гаргах тухай чиглэл өгсний дагуу хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200277

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,074,458.00	92,938,935.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		1,739,334.4
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,739,334.4
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	1,739,334.4
33	АВЛАГА	38,634,000.00	19,968,000.00
335	Бусад авлага	38,634,000.00	19,968,000.00
3351	Байгууллагаас авах авлага	37,434,000.00	19,968,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,200,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	47,440,458.00	71,231,601.00
351	Түүхий эд материал	9,819,480.00	7,153,653.00
35110	Тусгай зориулалттай материал	9,819,480.00	7,153,653.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	901,781.00	5,811,241.00
354	Хангамжийн материал	36,719,197.00	58,266,707.00
35410	Бичиг хэргийн материал	3,718,735.00	3,847,035.00
35420	Аж ахуйн материал	19,998,162.00	15,539,872.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,086,000.00	1,498,500.00
35470	Бусад хангамжийн материал	11,916,300.00	37,381,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	896,676,768.35	901,271,176.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	896,676,768.35	901,271,176.90
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	875,636,768.35	880,231,176.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	694,221,502.62	694,221,502.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	-44,312,010.84	-55,390,013.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,300,000.00	40,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,900,000.00	-30,780,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	374,282,904.59	278,218,730.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	-176,728,700.17	-108,446,973.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,486,300.00	80,920,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,802,749.84	37,488,319.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,143,807.47	23,143,807.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,654,285.48	-4,567,856.85
393	Биет бус хөрөнгө	21,040,000.00	21,040,000.00
39301	Програм хангамж	5,690,450.00	5,690,450.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,690,450.00	-5,690,450.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,040,000.00	21,040,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	982,751,226.35	994,210,112.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,739,334.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,739,334.40
414	Урьдчилж орсон орлого	00.00	1,739,334.40
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
42217	Санхүүгийн бусад байгууллага	00.00	00.00
4222	Гадаад валют	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	982,751,226.35	992,470,777.90
51	Засгийн газрын хувь оролцоо	982,751,226.35	992,470,777.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,040,000.00	21,040,000.00
51101	Өмч: - төрийн	21,040,000.00	21,040,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	958,464,299.72	968,183,851.27
51210	Өмнөх үеийн үр дүн	00.00	958,464,299.72
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,719,551.55

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,246,926.63	3,246,926.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	982,751,226.35	994,210,112.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,013,339,692.41	747,302,462.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	242,604,092.41	44,045,162.03
120	Нийтлэг татварын бус орлого	242,604,092.41	44,045,162.03
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	242,604,092.41	44,045,162.03
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	770,735,600.00	703,257,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	640,042,700.00	669,740,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	640,042,700.00	669,740,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130,692,900.00	33,516,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,500,000.00	23,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,793,900.00	6,716,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,399,000.00	3,800,000.00
131106	Төсвийн урамшуулал		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	820,504,833.70	731,082,910.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	820,504,833.70	731,082,910.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	808,164,237.84	724,441,194.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,373,184.00	491,308,008.92
210101	Үндсэн цалин	366,267,512.76	380,427,197.24
210102	Нэмэгдэл	88,055,972.00	100,072,031.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,049,699.24	9,518,294.26
210104	Урамшуулал	-	1,290,486.30
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,959,050.14	60,824,723.52
210201	Тэтгэврийн даатгал	91,433,757.17	42,473,123.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,649,722.20	4,587,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,119,777.77	3,670,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	523,253.54	917,600.00

210205	Эрүүл мэндийн даатгал	5,232,539.46	9,175,800.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,108,965.00	58,532,191.06
210301	Гэрэл, цахилгаан	2,105,067.00	3,239,495.06
210302	Түлш, халаалт	53,182,800.00	53,182,800.00
210303	Цэвэр, бохир ус	1,821,098.00	2,109,896.00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	54,025,532.93	24,268,101.00
210401	Бичиг хэрэг	12,374,022.93	14,298,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,902,041.00	2,510,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,293,182.00	3,101,615.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	293,925.00	210,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,162,362.00	4,146,336.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,589,200.00	3,677,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	562,500.00	170,800.00
210604	Урсгал засвар	1,026,700.00	3,506,350.00
2107	Томилолт, зочны зардал	159,000.00	1,334,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	159,000.00	1,334,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,640,257.75	23,850,727.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	437,300.00	1,870,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,249.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	341,000.00
210807	Газрын төлбөр	60,000.00	50,500.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,639,708.75	20,959,977.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,309,048.02	60,646,293.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,475,520.00	6,186,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	366,400.00	888,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,467,128.02	53,571,143.48
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,340,595.86	6,641,715.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	490,000.00	2,382,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	490,000.00	2,382,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,712,595.86	3,609,965.50
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	4,318,380.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,394,215.86	3,609,965.50
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	138,000.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	138,000.00	
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		649,750.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		649,750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	192,834,858.71	16,219,551.55
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	6,500,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	6,500,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(6,500,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	192,834,858.71	9,719,551.55

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	946,049,640.32	833,598,102.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,314,040.32	130,340,802.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,314,040.32	130,305,802.21

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	770,735,600.00	703,257,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	640,042,700.00	669,740,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	640,042,700.00	669,740,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130,692,900.00	33,516,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,500,000.00	23,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,793,900.00	6,716,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,399,000.00	3,800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	946,049,640.32	831,858,767.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,049,640.32	831,858,767.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	758,395,004.14	696,615,584.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	460,073,184.00	465,483,732.44
210101	Үндсэн цалин	362,967,512.76	354,602,920.76
210102	Нэмэгдэл	88,055,972.00	100,072,031.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,049,699.24	9,518,294.26
210104	Урамшуулал	-	1,290,486.30
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,970,379.14	85,449,000.00
210201	Тэтгэврийн даатгал	82,710,409.49	67,097,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,613,400.14	4,587,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,890,720.10	3,670,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	705,077.23	917,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,050,772.18	9,175,800.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,108,965.00	58,532,191.06
210301	Гэрэл, цахилгаан	6,201,067.00	12,093,916.06
210302	Түлш, халаалт	49,086,800.00	44,328,379.00
210303	Цэвэр, бохир ус	1,821,098.00	2,109,896.00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	19,370,600.00	24,996,911.00
210401	Бичиг хэрэг	7,425,300.00	14,301,250.00
210402	Тээвэр, шатахуун	3,902,041.00	2,520,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,293,182.00	3,101,615.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	293,925.00	210,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,456,152.00	4,862,846.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,870,407.00	50,853,850.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	839,907.00	47,253,600.00
210602	Тавилга	37,434,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	562,500.00	170,800.00
210604	Урсгал засвар	1,034,000.00	3,429,450.00
2107	Томилолт, зочны зардал	159,000.00	1,334,000.00
210702	Дотоод албан томилолт	159,000.00	1,334,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,549.00	2,890,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	437,300.00	1,870,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,249.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	341,000.00
210807	Газрын төлбөр	60,000.00	50,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,841,920.00	7,075,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,475,520.00	6,186,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	366,400.00	888,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,654,636.18	135,243,183.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	490,000.00	2,382,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	490,000.00	2,382,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,026,636.18	132,211,433.31
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	179,632,420.32	128,566,467.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,394,215.86	3,644,965.50
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	138,000.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	138,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		649,750.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		649,750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		1,739,334.40
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		1,739,334.40

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,739,334.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл					
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн					
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,040,000.00	3,246,926.63	958,464,299.72		982,751,226.35
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	21,040,000.00	3,246,926.63	958,464,299.72		982,751,226.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,040,000.00	3,246,926.63	958,464,299.72		982,751,226.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		9,719,551.55		9,719,551.55

D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,040,000.00	3,246,926.63	968,183,851.27		992,470,777.90
-----	---------------------------------------	---------------	--------------	----------------	--	----------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	669,740,900.00	666,130,934.50	3,609,965.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	669,740,900.00	666,130,934.50	3,609,965.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	667,568,300.00	664,030,934.50	3,537,365.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,628,000.00	465,483,732.44	144,267.56
210101	Үндсэн цалин	390,808,500.00	354,602,920.76	36,205,579.24
210102	Нэмэгдэл	63,995,500.00	100,072,031.12	(36,076,531.12)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,824,000.00	9,518,294.26	1,305,705.74
210104	Урамшуулал	-	1,290,486.30	(1,290,486.30)
210105	Гэрээт ажлын хөлс			
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,449,000.00	85,449,000.00	-
210201	Тэтгэврийн даатгал	67,097,400.00	67,097,400.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	4,587,900.00	4,587,900.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,670,300.00	3,670,300.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	917,600.00	917,600.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	9,175,800.00	9,175,800.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,505,200.00	58,532,191.06	2,973,008.94
210301	Гэрэл, цахилгаан	6,277,300.00	12,093,916.06	(5,816,616.06)
210302	Түлш, халаалт	52,815,400.00	44,328,379.00	8,487,021.00
210303	Цэвэр, бохир ус	2,412,500.00	2,109,896.00	302,604.00
210304	Байрны түрээс			
2104	Хангамж, бараа материалын зардал	24,019,100.00	24,001,361.00	17,739.00
210401	Бичиг хэрэг	14,325,800.00	14,301,250.00	24,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,508,400.00	2,520,400.00	(12,000.00)

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,014,600.00	3,101,615.00	(87,015.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	310,600.00	210,800.00	99,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,859,700.00	3,867,296.00	(7,596.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,522,700.00	25,451,400.00	71,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,406,500.00	24,373,600.00	32,900.00
210602	Тавилга			
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	170,800.00	170,800.00	-
210604	Урсгал засвар	945,400.00	907,000.00	38,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,360,000.00	1,334,000.00	26,000.00
210701	Гадаад албан томилолт			
210702	Дотоод албан томилолт	1,360,000.00	1,334,000.00	26,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,195,800.00	2,890,750.00	305,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,135,700.00	1,870,200.00	265,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	445,000.00	432,000.00	13,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,800.00	74,250.00	26,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	100,800.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	341,000.00	341,000.00	-
210807	Газрын төлбөр	50,500.00	50,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	888,500.00	888,500.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	888,500.00	888,500.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	888,500.00	888,500.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,172,600.00	2,100,000.00	72,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,172,600.00	2,100,000.00	72,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,172,600.00	2,100,000.00	72,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	669,740,900.00	667,870,268.90	1,870,631.10
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	669,740,900.00	666,130,934.50	3,609,965.50
131001	Улсын төсвөөс санхүүжих	669,740,900.00	666,130,934.50	3,609,965.50
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		1,739,334.40	(1,739,334.40)

120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,739,334.40	(1,739,334.40)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,739,334.40	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
610001	Төсвийн байгууллага	1	1	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	41.00	
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00	
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	
620004	Гэрээт ажилтан	5	5	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		32,866,650.00	- 32,866,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		32,866,650.00	- 32,866,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		32,584,650.00	- 32,584,650.00
2104	Хангамж, бараа материалын зардал		995,550.00	-995,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		995,550.00	-995,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		25,402,450.00	- 25,402,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		22,880,000.00	- 22,880,000.00
210602	Тавилга		00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		00.00	00.00
210604	Урсгал засвар		2,522,450.00	-2,522,450.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,186,650.00	-6,186,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,186,650.00	-6,186,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	282,000.00	-282,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		282,000.00	-282,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		282,000.00	-282,000.00

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	33,516,400.00	- 33,516,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		33,516,400.00	- 33,516,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		23,000,000.00	- 23,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,716,400.00	-6,716,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,800,000.00	-3,800,000.00
131106	Төсвийн урамшуулал		00.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх эрхэм зорилготой байгууллага байна.

Тус хэлтэс дараах зорилтуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.
- Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна.
- Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.
- Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит тогтмол хийж, үр дүнг сайжруулна.
- Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана.
- Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.
- Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн Улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журам, заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт орсон.

Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 374 тоот тогтоолоор иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг шинэчлэн батлуулав.

"Үндэсний гадаад паспортын загвар, тодорхойлолт батлах тухай" Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлуулж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэдэд тоон гарын үсгийг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгож эхэлсэн.

Иргэний улсын бүртгэлийн гэрчилгээнд иргэний бүртгэлийн дугаарыг ил харагдах бичилтээр бичих ажлыг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс, Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт"-д иргэний бүртгэлийн дугаарыг бичих ажлыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.

Түүнчлэн төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцохдоо иргэний бүртгэлийн дугаарыг ашиглах боломжтой болсны зэрэгцээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэнд иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан цахим шуудангийн хаягийг нээсэн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-ээр нийт 90 лавлагаа, үйлчилгээ цахимаар үзүүлж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/427 дугаар тушаалаар "Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-06 маягт/-д өөрчлөлт оруулж, "Барьцааны гэрээ /ипотек/-ний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-13 маягт/"-ийн загварыг шинээр батлан 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг нээлттэй, ил тод байлгах программыг боловсруулж, Эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн систем <https://opendata.burtgel.gov.mn/>-д байршуулсан зэрэг өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,458.9 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			/мянган төгрөгөөр/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	1,739.3	1,739.3
Авлага	38,634.0	19,968.0	-18,666.0
Бараа материал	47,440.5	71,231.6	23,791.1
Үндсэн хөрөнгө	896,676.8	901,271.2	4,594.4
Нийт хөрөнгө	982,751.2	994,210.1	11,458.9
Өр төлбөр	0	1,739.3	1,739.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	982,751.2	992,470.7	9,719.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	982,751.2	994,210.1	11,458.9

Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,739.3 мянган төгрөг байгаа нь арилжааны банкин дахь үйлчилгээний орлогын дансны үлдэгдэл бөгөөд тухайн оны урьдчилж орсон орлого дансанд тусгагдаж Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт төвлөрүүлэх өглөгийн дүнгээр харагдаж байна.

Авлагын дансны үлдэгдэл 18,666.0 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүмүүсээс авах авлага 1,200.0 мянган төгрөгөөр, байгууллагаас авах авлага 17,466.0 мянган төгрөгөөр барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23,791.1 мянган төгрөгийн өсөлтөд аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 22,880.0 мянган төгрөгийн үнэ бүхий иргэд өөртөө үйлчлэх Киоск машиныг орлогод авах зөвшөөрөл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гараагүй байгаа тул бусад хангамжийн материал ангилалд түр орлогод авсан нь голчлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 901,271.2 мянган төгрөг болж 4,594.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бараа материалаас шилжүүлэн авсан 6,500.0 мянга,

бусад эх үүсвэрээс 37,434.0 мянга, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 15,638.0 мянга, нийт 59,572.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 107,103.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна. Мөн тайланд онд 53,571.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,719.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 813,941.3 мянган төгрөгөөр тоохон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 266,599.8 мянган төгрөгөөр бууруулж, 547,341.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төсөлд барилгын их засвар болон тэтгэвэрт гарах албан хаагчид нэг удаа олгох мөнгөн тэтгэмжийг тооцоолж явуулсан бөгөөд дээрх зардлууд нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын төсөвт олгогдсон болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн зарим зардал танагдсанаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 122,399.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 669,740.9 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Улсын бүртгэл мэдээлэл /70406/ хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал /80101/, ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/ гэсэн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 669,740.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 669,740.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Улсын бүртгэлийн ерөнхий газарт үйл ажиллагааны орлого 128,566.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 666,130.9 мянган төгрөг буюу 99 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны зардлаас 3,609.9 мянган төгрөгийг хэмнэж улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	667,568.3	664,030.9	3,537.4	99.5
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,172.6	2,100.0	72.6	96.6
	Нийт	669,740.9	666,130.9	3,609.9	98.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 23,000.0 мянга, Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 6,716.4 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,800.0 мянга, нийт 33,516.4 мянган төгрөгийн орлого орж, Бараа үйлчилгээний зардалд 32,584.6 мянга, урсгал шилжүүлэг 282.0 мянга, 32,866.6 мянган төгрөгийн зардал гарсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 649.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 82 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8,205.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 731.1 сая төгрөгийн 1.0 хувь буюу 7,310.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,848.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн хэлтсийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Улсын бүртгэлийн хэлтэс нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан иргэд өөртөө үйлчлэх коиск машиныг 22,880.0 мянган төгрөгөөр худалдан авсныг Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүй учир бусад хангамжийн бараа материал дансанд бүртгэсэн байна. Дараагийн аудитаар тухайн хөрөнгийн данс бүртгэлд тусгасан эсэхийг шалгах.
2. Улсын бүртгэлийн Ерөнхий газраас хуваарилсан 19,968.0 мянган төгрөгөөр архивын нягтруулсан шүүгээ худалдан авахаар “Лүндээ-Очир” ХХК-тай гэрээ байгуулан санхүүжилтийг олгож, санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна. Гэрээний дагуу тухайн хөрөнгийг 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдөр нийлүүлэхээр байх тул дараагийн аудитаар тухайн хөрөнгө биетээр ирсэн эсэхийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,624.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулга хийлгэсэн.

Залруулсан алдаа

Тайлант онд ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалингийн зардалд 24,624.3 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсныг санхүүгийн үр дүнгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд тусгасан байсныг цалингийн зардалд тусгуулан залруулга хийлгэсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын бүртгэлийн хэлтэс	1	24,624.3			1	24,624.3	1	24,624.3				
Дүн	1	24,624.3			1	24,624.3	1	24,624.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Улсын бүртгэлийн хэлтэс	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Л.НАМЖИЛ/

2023 оны 02 сарын 15-ны өдөр